



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2009 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 274

Улаанбаатар хот

“Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хийх газар дээрх хяналт, шалгалтын журам”-ыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хийх газар дээрх хяналт шалгалтын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам” батлах тухай 188 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Батлагдсан журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос баталсан журам, заавар, бусад холбогдох хууль тогтоомжийг даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогч компани (цаашид “даатгалын байгууллага” гэх) хэрхэн хэрэгжүүлж байгааг Хорооны хянан шалгагч шалгахад мөрдлөг болгоно.

ХОЁР.Нэр томьёо

2.1.Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог дараах утгаар ойлгоно:

2.1.1.“*Иж бүрэн шалгалт*” гэж Хорооноос батлагдсан хуваарь, удирдамжийн хүрээнд даатгалын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт материал, даатгалын гэрээний хэрэгжилт, нөөц сангийн тооцоололт, зарцуулалт, хохирлын нөхөн төлбөрийн тооцоололт, олголт, тухайн даатгалын байгууллагын дүрэм, гаргасан журам, заавар, шийдвэрүүдэд тулгуурлан үйл ажиллагааг бүхэлд нь хамруулж нарийвчлан шалгаж, үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөхийг хэлнэ.

2.1.2.“*Хэсэгчилсэн шалгалт*” гэж даатгалын байгууллага болон холбогдох бусад байгууллагаас ирсэн өргөдөл, гомдол, мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан шүүмжлэлийн мөрөөр, эсхүл Хорооноос шалгах шаардлагатай гэж даатгалын байгууллагын үйл ажиллагааны тодорхой хэсгийг асуудлын нэр төрлөөр нь шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөхийг хэлнэ.

2.1.3.“*Шалгалтын удирдамж*” гэж даатгалын байгууллагын үйл ажиллагаанд шалгалт хийхэд удирдлага болгох зүйлийг тодорхойлсон баримт бичгийг хэлнэ.

ГУРАВ.Шалгалтын зорилго, ангилал

3.1.Шалгалтын зорилго нь тухайн даатгалын байгууллагын үйл ажиллагаа нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавраар тавигдсан шаардлагыг хангаж ажиллаж байгаа эсэх, ирээдүйд учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв, бодитой эсэх, үйл ажиллагаанд нөлөөлж болох аливаа асуудлыг илрүүлж, хөрөнгийн хүрэлцээ, төлбөрийн чадварыг хангуулж ажиллуулахад оршино.

3.2.Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хийх шалгалтыг хэлбэрээр нь иж бүрэн шалгалт ба хэсэгчилсэн шалгалт гэж ангилна.

ДӨРӨВ. Шалгалт явуулах үе шат

4.1.Шалгалт нь дараах үе шаттай явагдана:

4.1.1.Шалгалтыг төлөвлөх, шалгалтын бэлтгэл хангах.

4.1.1.1.Тухайн жилийн эхэнд даатгалын байгууллагуудад хийх шалгалтын төлөвлөгөөг сар, улирлын хуваарьтай хийж Ажлын албаны даргаар батлуулна;

4.1.1.2.Хорооноос шалгалт хийх шаардлагатай гэж үзвэл даатгалын байгууллагуудад төлөвлөгөөт бус шалгалтыг хийнэ;

4.1.1.3.Төлөвлөгөөт хуваарийн дагуу шалгалтын удирдамжийг боловсруулж, Хорооны гишүүн дэд даргаар хянуулж, Хорооны даргаар батлуулна;

4.1.1.4.Хянан шалгагч (улсын байцаагч) нь шалгалт хийх даатгалын байгууллагын (санхүүгийн тайлан, холбогдох бусад мэдээллийн) талаарх судлагааг урьдчилж хийсэн байна.Үүнд:

а.Хороонд даатгуулагч иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг судалж үзэх;

б.Шалгах гэж байгаа даатгалын байгууллагын талаарх мэдээллийг тус байгууллагын хувийн хэрэг болон архивын материалаас үзэж судлах;

в.Шалгалтын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, заавар, журмыг судлах;

г.Шалгалттай холбоотой бусад ажил.

4.1.2. Шалгалт хийгдэж буй байгууллага дээр ажиллах.

4.1.2.1.Хянган шалгагч (улсын байцаагч) нь шалгалтын удирдамжийн нэг хувийг даатгалын байгууллагын удирдлагад танилцуулна;

4.1.2.2.Шалгалтанд хамрагдах хугацааны жил, улирлын санхүүгийн тайлан тэнцэл, даатгалын гэрээ, хохирлын нөхөн төлбөрийн болон бусад холбогдох баримт материалыг акт үйлдэж хүлээн авна;

4.1.2.3.Годорхой бус зүйлийг холбогдох албан тушаалтнаас асууж тодруулах, ноцтой зөрчил дутагдалтай холбоотой баримт материалын хуулбарыг авна;

4.1.2.4.Даатгалын байгууллагын удирдлага, зохион байгуулалт, салбар нэгжүүдийн хоорондын уялдаа, дотоод хяналтын системтэй танилцах, хяналтын баримт материалыг судалж танилцана;

4.1.2.5.Даатгалын байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулсан аудиторын дүгнэлт, актуарчийн тооцоолж гаргасан даатгалын хураамжийн хувь хэмжээ, нөөцийн сангийн судалгаа тооцоололтой танилцаж шинжилнэ;

4.1.2.6.Тухайн даатгалын байгууллагын бизнес төлөвлөгөө, түүний гүйцэтгэл эрсдэлийн менежмент (давхар даатгалын хамгаалалт, хамтарсан даатгал) зэргийг хянаж үзнэ;

4.1.2.7.Хороонд даатгалын байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайлан, бусад статистикийн мэдээллүүд нь үнэн зөв, хууль, журам, зааврын дагуу хийгдсэн эсэхийг шалгана;

4.1.2.8.Даатгалын байгууллагад улирлын зайны хяналтаар болон албан

шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг үзнэ;

4.1.2.9. Даатгагч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч нарын хоорондын хамтын ажиллагааг (даатгалын гэрээ, хурамжийн орлого, шимтгэл зэргийг) шалгана;

4.1.2.10. Шалгалтын явцад даатгалын байгууллагуудаас шаардлагатай баримт материалыг гаргуулж үзэх, хуулбарлаж авч болно;

4.1.2.11. Даатгалын байгууллагын холбоотой этгээдийг шаардлага гарсан үед өргөжүүлэн шалгаж болно (Хорооны дарга, Хорооны гишүүн дэд дарга, газрын удирдлагад танилцуулж, тэдгээрийг шалгах эсэхийг шийдвэрлүүлэх);

4.1.2.12. Хянан шалгагч (улсын байцаагч) нь шалгалт хийхдээ аудитор, актуарчийн, мэргэжлийн байгууллагын тусалцааг авч болно (Хорооны дарга, Хорооны гишүүн дэд дарга, Ажлын албаны дарга, газрын даргад танилцуулж, шийдвэрлүүлэх);

4.1.2.13. Даатгалын байгууллагын удирдлага зохион байгуулалт, компанийн засаглал, дотоод хяналтын системийн талаарх үйл ажиллагааг үзнэ. Үүнд:

а. Хувь нийлүүлэгчдийн болон захирлуудын зөвлөлийн хурлын тэмдэглэл, шийдвэр, аудитын дүгнэлтийг унших, хэрэв боломжтой бол актуарын болон электрон мэдээлэл боловсруулалтын байлыг шалгах;

б. Хувь нийлүүлэгчийн бүтэц болон дүрмийн сангийн хөрөнгийн эх үүсвэрийн шинжилгээ хийх;

в. Удирдлага зохион байгуулалтын хүчин чадал, зохистой байдал, түүний үр ашиг, удирдлага зохион байгуулалтын уян хатан байдал, алдаагаа засаж залруулах чадварт (ялангуяа захирлуудын зөвлөлд орсон өөрчлөлтийн дараа) үнэлэлт өгөх;

г. Даатгалын байгууллагын дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хоорондын уялдааг үнэлэх зорилгоор компанийн эрсдэлийг хянах систем болон дотоод ажлын явцыг шалгах;

д. Даатгалын байгууллагын хөрөнгө оруулалтыг үнэлэх, маргаантай болон балансын гадуурх мөнгөнд шинжилгээ хийх;

е. Даатгалын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, түүний групптэй холбоотой нэгжээс хамааралтай хүндрэл байгаа эсэхийг судалж шинжлэх.

4.1.2.14. Бизнес төлөвлөгөөг шалгаж, ирээдүйд боловсруулах бизнес төлөвлөгөөний талаар мэдээлэл авах зорилгоор даатгалын байгууллагын удирдлагатай уулзаж болно;

4.1.2.15. Даатгалын болон давхар даатгалын гэрээнүүдийг судалж шинжилнэ (давхар даатгалын хамгаалалт нь даатгалын байгууллагын санхүүгийн арга хэрэгслүүд болон түүний хамгаалж буй эрсдэлд тохирсон эсэх);

4.1.2.16. Даатгалын нөөцийн сан, хураамжийн хувь хэмжээний тооцоолол, даатгуулагч иргэд, байгууллагуудад олгосон хохирлын нөхөн төлбөрийг шинжилнэ;

4.1.2.17.Шалгалт дууссаны дараа жил, улирлын санхүүгийн тайлан тэнцэл, даатгалын гэрээ, бусад холбогдох баримт материалыг даатгалын байгууллагын холбогдох хүмүүст акт үйлдэж хүлээлгэж өгнө.

4.1.3. Шалгалтын тайлан, дүгнэлт бичих.

4.1.3.1.Хянан шалгагч (улсын байцаагч) нь даатгалын байгууллагад хийсэн шалгалтын хийх явцад илэрсэн зөрчил дутагдлын талаар ярилцаж, хэрхэн хүлээж авч байгааг мэдсэн байна;

4.1.3.2.Шалгалтын тайланд даатгалын байгууллагын хөрөнгийн хүрэлцээ, санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа, ашиг алдагдал, даатгалын хураамжийн орлого, хохирлын нөхөн төлбөр, эрсдэлийн тараан байршуулалт, зөрчил дутагдал, үйл ажиллагаа нь тогтвортой эсэх, төлбөрийн чадвар, хууль, журам, заавар зөрчсөн зэрэг үйл ажиллагаанд өгсөн үнэлэлт дүгнэлтийг тусгана (Ажлын албаны даргын 2008 оны 20 дугаар тушаалаар батлагдсан Даатгалын компанийн үйл ажиллагаанд газар дээр хийсэн шалгалтын тайлан бичих аргачлалын дагуу);

4.1.3.3.Шалгалтын тайланд үйл ажиллагааны чиглэл бүрээр мөрдөж буй хууль тогтоомж, заавар, журмын хэрэгжилт, илэрсэн зөрчил дутагдал, түүнийг хариуцах эзэн, авсан арга хэмжээ, шалгалтын дүнгээр авах арга хэмжээний талаарх санал, өгсөн үүрэг, албан шаардлага, зөвлөмжийн талаар тусгана;

4.1.3.4.Аудиторын дүгнэлт, актуарчийн судалгаа тооцоо хэрхэн хийгдсэн талаар шалгалтын тайланд тусгана;

4.1.3.5.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар (хэрэв зөрчил дутагдал илэрсэн бол) шалгалтын тайланд тодорхой дурдаж, зөрчигдсөн хууль тогтоомж, заавар, журмын заалтыг тодорхой тусгана;

4.1.3.6.Даатгалын байгууллагад гаргасан зөрчил дутагдалд үндэслэж хугацаатай албан шаардлага өгнө;

4.1.3.7.Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмжийн талаар хугацаатай үүрэг даалгавар өгнө;

4.1.3.8.Шалгалтын тайланг даатгалын байгууллагын удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулан, тэмдэг даруулж батлагаажуулалт хийнэ. Даатгалын байгууллагын удирдлага татгалзсан нөхцөлд тайлбарыг албан бичгээр гаргуулж авна;

4.1.3.9.Хянан шалгагч (улсын байцаагч) нь шалгалтын тайланд зөрчил дутагдал болон бусад шаардлагатай холбогдох баримтын хуулбар, даатгалын байгууллагын гаргасан тайлбарыг хавсаргана.

4.1.4.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах.

4.1.4.1.Хянан шалгагч (улсын байцаагч) нь зөрчил гаргасан даатгалын байгууллага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу захиргааны шийтгэл буюу торгуулийн арга хэмжээ ногдуулна;

4.1.4.2.Шалгалтын ажлын дүнг үндэслэн зөрчил гаргасан этгээдэд захиргааны

шийтгэл ногдуулах, түүний гүйцэтгэлийг хангуулах, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар хугацаатай албан шаардлага өгнө;

4.1.4.3.Хууль тогтоомжийг зөрчсөн нь илэрсэн тохиолдолд зөрчлийн тухай тэмдэглэл үйлдэж шийтгэвэр ногдуулах, түүнд зөрчсөн хууль тогтоомжийн зүйл, заалт болон харилцагч байгууллага, иргэдэд учруулсан хохирлын хэмжээг тодорхой дурдсан байна;

4.1.4.4.Хянан шалгагч (улсын байцаагч) нь шаардлагатай нөхцөлд (даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлэх, хүчингүй болгох) авах арга хэмжээний талаар саналаа боловсруулж Хорооны дарга, Хорооны гишүүн дэд дарга, Ажлын албаны дарга, газрын даргад танилцуулсны үндсэн дээр Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ;

4.1.4.5.Даатгалын байгууллагын албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр бол Хорооны дарга, Хорооны гишүүн дэд дарга, Ажлын албаны дарга, газрын даргад танилцуулж холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлнэ.

--ooOoo--